



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Г Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн G9206-MON төсөл”-ийн хүрээнд бий болсон 6 нэрийн, нийт 3,896,954,764.07 (гурван тэрбум найман зуун ерэн зургаан сая есөн зуун тавин дөрвөн мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг долоон мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Буцалтгүй тусламжаар бий болсон үл хөдлөх болон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132005537
15-n.huraldaah.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
281 дугаар тогтоолын хавсралт

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр "Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн G9206-MON төсөл"-ийн хүрээнд бий болсон орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт (товчоо)

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага
1	W1.1 багц буюу Говь-Алтай хяналттай шинэ ландфилл байгуулах ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	384,461,733.94	Говь-Алтай аймгийн өмчид (Говь-Алтай аймгийн "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ)
2	W3 багц буюу Говь-Алтай аймагт хаягдал шилжүүлэн буулгах төв, пүү ба хаягдал дахин ашиглах цэг барих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	1,245,493,013.01	
3	W1.2 багц буюу Сүхбаатар аймгийн хяналттай шинэ ландфилл байгуулах ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	405,881,946.96	Сүхбаатар аймгийн өмчид ("Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ)
4	W4 багц буюу Сүхбаатар аймагт хаягдал шилжүүлэн буулгах төв, пүү ба хаягдал дахин ашиглах цэг барих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	1,366,027,561.14	
5	W2 багц буюу Дархан-Уул аймгийн төвд хаягдал дахин ашиглах төвүүд байгуулах ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	178,090,689.35	Дархан-Уул аймгийн өмчид ("Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ)
6	W5 багц буюу Өвөрхангай аймагт хаягдлын пүү, хаягдал дахин ашиглах цэг барих ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	316,999,819.67	Өвөрхангай аймгийн өмчид ("Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ)
	Нийт дүн	3,896,954,764.07 (гурван тэрбум найман зуун ерэн зургаан сая есөн зуун тавин дөрвөн мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг долоон мөнгө)	